



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

Аян зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн А/01 дүгээр захирамж, нийслэлийн Засаг даргын 05 дугаар сарын 12-ний өдрийн А/648 дугаар захирамж, Газрын дүрмийн 4.1.3, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын соёлыг иргэд, жуулчдад түгээх, аялал жуулчлалын үйл ажиллагаагаар дамжуулан аялал жуулчлалын боловсролыг нэмэгдүүлэх аян зохион байгуулсугай.

2. Аян зохион байгуулах ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 108,000,000 /зуун найман сая/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналтад тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ

1150500302

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 06 сарын 10 өдрийн
А/31 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД БҮХ НИЙТИЙН АЯЛАЛЫН БОЛОВСРОЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ,
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖЛЫГ СУРТАЛЧЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ


2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр
хот

Улаанбаатар

Д/д	Хийгдэх ажлын нэрс	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах албан хаагч
1. Бүх нийтийн аялал жуулчлалын боловсролыг нэмэгдүүлэх, зөв аялах соёлыг түгээх арга хэмжээний хүрээнд:					
1	Улаанбаатар хотод 2022 онд зохион байгуулах олон улсын соёл, спорт, аялал жуулчлалын арга хэмжээнүүдээр дамжуулан иргэдийн аялал жуулчлалын боловсролыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Арга хэмжээнд оролцогч, сонирхогчдын тоо	50000	II-IV улирал	Б.Халиун Б.Жаргалан
2	“Зөв аялъя” Уриан дор “Улаанбаатар травэл экспо-2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	II Улирал	Б.Жаргалан
3	Бүх нийтийн аяллын боловсролыг нэмэгдүүлэх талаар сургалтуудыг шат дараатай зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	II-III улирал	Захиргаа, санхүүгийн хэлтэс - Э.Мөнхзул С.Туул Н.Алтанзаяа
4	Бүх нийтийн аяллын боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор аялал жуулчлалын зочлох үйлчилгээний салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, үйлчилгээний чанар стандартыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	Хамрагдсан ажилчдын тоо	500	II-IV улирал	Захиргаа, санхүүгийн хэлтэс - Э.Мөнхзул
5	Нийслэлийн Засаг даргаас 2022 оныг Иргэний жил болгон зарласантай холбоотойгоор ажилтай орлоготой хотын иргэнийг дэмжих ажлын хүрээнд “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт” хөдөлмөрийн яармаг зохион байгуулах	Хамруулсан хүний тоо	1200	II улирал	Б.Жаргалан

6	“Сити тур” төслийн хүрээнд хотын аяллын хөтөлбөрөөр дамжуулан иргэдэд нийслэл хотын түүх, өв соёлыг таниулах аялал зохион байгуулах	Хамруулсан хүний тоо	2500	II-III улирал	С.Туул Э.Оргилцэцэг
7	Дотоодын аялагчдад зориулан байгальд ээлтэй аяллыг сурталчлах, хөнгөлөлттэй аяллын үйлчилгээг бий болгох	Хэрэгжилтийн хувь	100%	II-IV улирал	Б.Жаргалан
8	Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр 21 аймгийн аялал жуулчлалын газартай хамтран ажиллах	Хэрэгжилтийн хувь	100%	II-IV улирал	
9	Улаанбаатар хотын онцлог бүхий брэндийг хөгжүүлэх, /Ulaanbaatar brand/ олон нийтэд сурталчилах	Хэрэгжилтийн хувь	100%	II-IV улирал	С.Туул
10	Улаанбаатар хотын гудамж талбайн газрын зургийг дрон болон архитектур гэрэл зурагт оруулах, “2D illustration map” хэлбэрээр гаргах	Хэрэгжилтийн хувь	100%	II-IV улирал	С.Туул
11	Улаанбаатар хотын танилцуулага веб /UB-365/ цахим хуудас	Хэрэгжилтийн хувь	100%	II-IV улирал	С.Туул
2. Соёлтой хотын иргэдийг бий болгох, гадаад дотоодын жуулчид, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, маркетингийн ажлын хүрээнд:					
1	Улаанбаатар хотын аялал жуулчлалын нэвтрүүлэг бэлтгэж, иргэдэд түгээн хотын соёлыг сурталчлах	Нэвтрүүлгийн тоо	8	II-IV улирал	С.Туул, Б.Цолмонгэрэл
2	Цахим сүлжээгээр иргэдийг олон нийтийн газраар зөв зохистой зорчих, бусдад хүндэтгэлтэй хандах зан төлвийг хэвшүүлэх уриалга гаргах, хэвлэмэл материал гаргах	Цахим сүлжээнд хандсан хүний тоо	1,000,000	II-IV улирал	Б.Цолмонгэрэл
3	Аялал жуулчлалын сурталчилгааны цахим танилцуулга, бэлтгэж, гадаад дотоодод сурталчлах	Сурталчилгааны тоо		II-IV улирал	С.Туул, Б.Цолмонгэрэл
4	Улаанбаатар уугуул иргэдийн хотын амьдарлын сониорхолтой түүхийг өгүүлэх цуврал нэвтрүүлэг бэлтгэх	Нэвтрүүлгийн тоо	20	II-IV улирал	С.Туул, Б.Цолмонгэрэл
5	Улаанбаатар хотын танилцуулага веб /UB-365/ цахим хуудас	Цахим сүлжээнд хандсан хүний тоо	1	II-IV улирал	Б.Ишдорж
6	Аяны хүрээнд сар бүр олон талт арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээнүүдийн тоо	12	II-IV улирал	С.Туул, Б.Цолмонгэрэл
7	Долоо хоног бүр нийслэлээс гаргасан шинэ шийдлийн тухай сурвалжлага зурган нийтлэл гаргах	Сурвалжлага зурган мэдээллийн тоо	52	II-IV улирал	С.Туул, Б.Цолмонгэрэл

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2022 оны 06 сарын 10 өдрийн
А31 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
ЗАРДЛЫН ТӨСӨВ

2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Бүх нийтийн аяллын боловсролыг нэмэгдүүлэх, хотын соёлыг түгээх цуврал арга хэмжээ	1	10 000 000	10 000 000
2	Улаанбаатар иргэдийн хотын амьдарлын сониорхолтой түүхийг өгүүлэх цуврал нэвтрүүлэг бэлтгэх	20	1 500 000	30 000 000
3	Улаанбаатар хотын танилцуулага веб /УВ-365/ цахим хуудас	1	24 000 000	24 000 000
4	Аяны хүрээнд сар бүр улс төр, урлаг соёлын сэтгүүл, сонин гаргах	12	2 000 000	24 000 000
5	Долоо хоног бүр нийслэлээс гаргасан шинэ шийдлийн тухай сурвалжлага, зурган нийтлэл гаргах	52	384 615	20 000 000
НИЙТ				108 000 000

--o0o--